



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

*dodo* оны 10 сарын 08 өдөр

Дугаар *1/50/1*

Улаанбаатар хот

**Б.Ариунсанаад сахилгын  
шийтгэл ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Баатарын Ариунсанаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Улсын бүртгэгч цахим мэдээллийн санд эх нотлох баримт бичигт үндэслэж, улсын бүртгэлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн программ хангамж, тоног төхөөрөмжийг ашиглан үнэн зөв оруулна”, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 1.5.2 дахь заалт “хуульд заасны дагуу бүрдүүлсэн баримт бичиг дэх холбогдох мэдээллийг мэдээллийн санд үнэн зөв оруулж бүртгэх” гэж заасныг зөрчин холбогдох мэдээллийг алдаатай бүртгэж, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7, 16.8 дахь хэсэгт заасан Иргэний үнэмлэх олгох хугацааг хэтрүүлэн, албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь хяналтын улсын байцаагчийн 2020 оны 2604, 3969, 3970, 3971 тоот дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Б.Ариунсанаад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /Д.Оюунбилэг/-т, тушаалын хэрэгжильтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

571004373